



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд:


I. ХЭЛЭЛЦСЭН нь: “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл”-ийн хүрээнд шинээр баригдсан хоногт 24000 м.куб бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламжийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд байгуулсан санхүүгийн протокол, зээлийн гэрээний дагуу хэрэгжүүлсэн “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл”-ийн хүрээнд шинээр баригдсан хоногт 24000 м.куб бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн ашиглагч байгууллагаар “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг сонгов.

2. Цэвэрлэх байгууламжийн зээлийн эргэн төлөлтийн асуудлыг судлан “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газарт үүсэх зардлыг бууруулах, зээлийн хүүг хөнгөлөх хүсэлтийг Сангийн яаманд тавьж шийдвэрлүүлэх;

3. Зээлийн хөрөнгөөс авсан эд хөрөнгө нь төрийн өмчид хамаарах бөгөөд Дамжуулан зээлдүүлэх гэрээ дуусгавар болох хүртэл зээлдэгч нь тайлан тэнцэлдээ өглөг хэлбэрээр бүртгэхээр тус тус тогтов” гэжээ.



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

000047